



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/487

Ховд

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ажиллах журам, ажлын хэсгийг мэдээллээр хангах журмыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 77 дугаар тогтоолоор баталсан тул аймгийн Засаг даргын 2018 оны "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" А/715, 2019 оны "Журам батлах тухай" А/227 дугаар захирамжуудыг хүчингүй болгосугай.

2. Захирамж хүчингүй болсон тухай холбогдох байгууллага, албан тушаалтнуудад мэдэгдэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Н.Ганзориг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ДҮГЭРЖАВ

